

ТҮҮХИЙН ХИЧЭЭЛД «ТАЙМЛАЙН» ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЛЭХ АРГА ЗҮЙН АСУУДАЛД

Х.Баярмаа, магистр, МУБИС

Abstract: In today's teaching practice, ICT has been commonly used as a great source of information for both teachers and students. Despite the fact that IT has an enormous educational potential, for instance, the active involvement of students in the learning process are determined by their acquired skills to search information from the various sources, analyze, summarize, and systematize information about the subject, and to work in groups. This article is about a Web service that can be used most effectively in the work of history teachers. One of them is a Web-based service Timeline. Today, its timeline can be used to build a number of web services. The main advantage of timeline service for the use in training teachers and students is to create their own timeline. Timeline can create Web 2.0 services.

Түлхүүр үг: интернет, цахим үйлчилгээ, түүхийн сургалт, web 2.0, таймлайн

Өнөөдөр сургуулийн өмнө мэдээллийн нийгэмд ажиллаж амьдрах хойч үеийнхнийг бэлтгэх зорилт зүй ёсоор тулгарч байгаа билээ. Энэхүү шаардлагын үүднээс сургалтад МХТ-ийг нэвтрүүлж, цахим мэдээлэл, хэрэглэгдэхүүн сургалтын үр ашигтай хэрэгсэл болсоор байна.

Багш сургалтын үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж, сурагчдын сурах үйлийг удирдан ажиллахад хичээлийн агуулга, арга зүйгээ оновчтой төлөвлөсөн байхаас гадна түүнийгээ дэмжихээр боловсруулсан сургалтын цахим хэрэглэгдэхүүн чухал юм [Цэдэвсүрэн Д, 2012.т.113]. Цахим мэдээллийг түүхийн хичээлд өргөн хэрэглэх боломж бүрдсэн гэж хэлж болно. Тухайлбал, 2013 онд хийсэн судалгаагаар МХТ-ийг сургалтад нэвтрүүлэх тоног төхөөрөмж жил ирэх тусам нэмэгдэж, цахим орчин сайжирсан гэсэн дүн гарсан байна [Цэдэвсүрэн Д нар, 2013.т.41].

Интернетийн мэдээллийн сангаас багш, бичвэр мэдээлэл, баримт бичиг, үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүн, тэдгээрийг сургалтад хэрэглэх аргачлал зэргийг сонгон авах боломжтой юм. Мөн бэлэн боловсруулсан хичээл, танин мэдэхүйн дасгал, даалгавар, тоглоом, слайд, видео – бичлэг зэргийг авч ашиглаж байдаг. Багш цахим орчинд бусадтай санал бодол, арга туршлагаа солилцох, түүхийн хичээлийн арга зүйн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй ашиглах боломжтой юм.

Түүхийн сургалтад цахим нөөцийг хэрэглэж буй өнөөгийн бодит байдлыг тодруулах зорилгоор 2015 оны 11 дүгээр сарын 6-нд багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцсон нийслэлийн ЕБ-ын сургуулиудын түүх, нийгмийн ухааны 55 багшаас дараах бичил судалгааг авсан болно. Судалгааны дүнг асуулт бүрээр нэгтгэн харуулбал,

1. Та интернетийг сургалтад ашигладаг уу?

	Тоо	Хувь
Тийм	51	92.7
Үгүй	4	7.3
Нийт	55	100.0

Нийт багш нарын 92.7 хувь нь интернетийг сургалтад ямар нэг хэмжээгээр ашигладаг гэсэн нь цахим нөөцийг сургалтад ашиглах талаар санаачилгатай ажиллаж байгааг харуулж байна.

2. Та интернетэд хэрхэн холбогддог вэ?

	Тоо	Хувь
Ажил дээр	36	65.5
Гэрт	15	27.3
Модем ашигладаг	4	7.3
Нийт	55	100.0

Эдгээр багш нараас 65.5 хувь нь ажлын байран дээр интернетэд холбогддог, мөн гэртээ болон модем ашиглан интернетэд холбогдох боломжтой тул сургалтын үйл ажиллагаанд цахим мэдээллийг ашиглах үндсэн нөхцөл бүрдсэн гэж хэлж болох юм.

3. Интернетийг сургалтад хэрхэн ашигладаг вэ?

	Тоо	Хувь
Агуулга боловсруулах, баяжуулах	11	20.0
Арга зүйн туслалцаа авах	3	5.5
Үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүн ашиглах	20	36.4
Бүгд	21	38.2
Нийт	55	100.0

Багш нар интернетийг ихэвчлэн цахим хэрэглэгдэхүүн ашиглах, сэдвийн агуулгыг баяжуулах боловсруулах чиглэлээр сургалтын үйл ажиллагаанд ашигладаг байна.

4. Мэдээлэл эрж хайхдаа ямар мэдээллийн системийг голчлон ашигладаг вэ?

	Тоо	Хувь
Албан ёсны нөөц (БСШУЯ сайт гэх мэт)	15	27.3
Нэвтэрхий толь, лавлах (вики, төсөл гэх мэт)	12	21.8
Түүхийн мэргэжлийн нөөцийн сан (Хронос портал гэх мэт)	7	12.7
Арга зүйн хэрэглэгдэхүүн (hicheel.mn гэх мэт)	4	7.3
Үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүний нөөц (slideshare.net гэх мэт)	16	29.1
Бусад	1	1.8
Нийт	55	100.0

Тийм учраас үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүний нөөц, цахим лавлах, нэвтэрхий толь бүхий цахим хуудсуудыг голчлон ашигладаг байна.

5. Та интернетийн ямар хэл дээрх мэдээллийг голчлон ашигладаг вэ?

	Тоо	Хувь
Монгол хэл	47	85.5
Орос хэл	1	1.8
Англи хэл	7	12.7
Нийт	55	100.0

6. Та интернетийн мэдээллийг ямар түвшинд ашигладаг вэ?

	Тоо	Хувь
Сургалтад цахим мэдээллийг ашиглах	23	41.8
Сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг сургалтад ашиглах	20	36.4
Сургалтын зориулалттай вэб (цахим хуудас, үйлчилгээ)-ийн сан	7	12.7
Сургалтын вэб (цахим хуудас) хэрэглэгдэхүүн боловсруулах	5	9.1
Нийт	55	100.0

Нийт багш нарын 85.5 хувь нь зөвхөн монгол хэл дээрх цахим мэдээллийг ашигладаг байна. Энэ нь цахим мэдээллийг сургалтад үр ашигтай ашиглахад тулгарч байгаа гол бэрхшээл гэж хэлж болно. 2013 онд хөдөө орон нутгийн багш нараас авсан судалгаанд МХТ-ийг сургалтад ашиглахад тулгамдаж буй асуудлын 3-т энэхүү асуудал мөн хөндөгдсөн байна (Цэдэвсүрэн, 2012, х114).

Багш нар интернетээс бэлэн мэдээлэл, хэрэглэгдэхүүнийг авч ашигладаг хэдий ч сургалтын цахим үйлчилгээг (сервис) сургалтад төдийлөн ашигладаггүй байна. 2013 онд МХТ-ийг сургалтад ашиглах чиглэлээр багш нарт ямар дэмжлэг, туслалцаа шаардлагатай байгаа талаар хөдөө орон нутгийн 424 багшаас авсан судалгаагаар багш нарын 240 нь вэб мэдээлэлтэй

ажиллах чадвар, сургалтын блог болон вэб бүтээх чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн сургалт нэн шаардлагатай гэсэн хариулт өгсөн байна (Батдулам, 2013, х.140).

Өнөөдөр цахим мэдээллийн орчин сургалтад зориулсан тусгай цахим үйлчилгээ зэргээр улам баяжиж, өргөжиж байна. Ялангуяа хэрэглэгчдийн оролцоотойгоор хөгжүүлж, өргөжүүлж болох цахим үйлчилгээ нэвтэрч эхэлжээ (ерөнхийд нь Web 2.0² гэж нэрлэдэг¹). Тэдгээрийг сургалтад ашиглах нь сурагчдыг сургалтад идэвхтэй татан оролцуулах, мэдээллийг ерөнхийлөн дүгнэх, задлан шинжлэх, сэдвээр нь ангилах, бүлгээр ажиллах, янз бүрийн эх сурвалжаас мэдээллийг хайх, олох чадвар эзэмшүүлэх зэргээр сургалтын үлэмж нөөц боломжийг агуулж байдаг гэж судлаачид үзжээ (Брыкова, 2010).

Бүх судлагдахуун, судлагдахуун хооронд ашиглаж болохуйц нийтлэг шинжтэй цахим үйлчилгээ төдийлөн байдаггүй: зарим үйлчилгээг хүмүүнлэгийн салбарт ашиглаж болох бол нөгөө нэгийг нь математик, газарзүй, байгаль шинжлэл, биологи эсвэл түүхийн салбарт ашиглах жишээтэй. Цахим үйлчилгээ нь ямар судлагдахуунд илүү тохиромжтой вэ гэдгийг сайтар ойлгосон цагт түүнийг үр ашигтай ашиглах боломж төдий чинээ их байх болно.

Энэхүү өгүүлэлээрээ бид хүмүүнлэгийн салбарт тухайлбал, түүхийн сургалтад үр ашигтай ашиглаж болох цахим үйлчилгээний тухай өгүүлэх болно. Ийм цахим үйлчилгээний нэг нь түүхэн үйл явдлыг он цагийн дарааллаар байрлуулсан цаг хугацааны шатлал буюу таймлайн юм. Таймлайныг (англиар Timeline-үгчилбэл “он цагийн шугам” гэсэн үг) он цаг, тухайн он цагт болсон үйл явдлыг тэмдэглэсэн шугам гэж ойлгож болно. Мөн он цагийн хэлхээс, хүснэгт гэж болно.

Сурагчид 6-р ангидаа анх он тооллын шугамтай танилцаж, дэвтэртээ зурж, үйл явдлын

¹ Web 2.0 (Тим О, Рейллийн тодорхойлолт) — «Web 2.0» нэр томъёо нь хэрэглэгчид нь идэвхтэй хөгжүүлж, сайжруулж байдаг блог, wiki, нийгмийн сүлжээ зэрэг төсөл, үйлчилгээг илэрхийлнэ.

он цагийг тэмдэглэж сурдаг. Түүхэн чухал үйл явдлын он цагийг тогтоохоос гадна түүхэн үйл явдлууд хоорондоо хичнээн жилийн зайтай өрнөсөн, хэрхэн, ямар зүй тогтлоор холбогдож байгааг ойлгох чадвар чухал юм. Ийм чадвар эзэмшүүлэхийн тулд түүхийн сургалтын арга зүйд он тооллын шугам, он дарааллын хүснэгт, үйл явдлуудын зэрэгцүүлсэн хүснэгт ашиглаж, сурагчид янз бүрийн үеэр он дарааллын болон зэрэгцүүлсэн хүснэгт хийж байдаг. Гэхдээ түүхэн чухал үйл явдлын он цагийг тогтоолгох, хоорондоо холбоо хамаарал бүхий үйл явдлуудын бүхэллэг дүр зургийг бий болгоход тодорхой бэрхшээлтэй тулгардаг, мөн их цаг хугацаа шаарддаг гэдэг нь нууц биш юм.

Таймлайныг сургалтад ашигласнаар ийм бэрхшээлийг даван туулж болох юм. Юун түрүүн таймлайныг түүхэн үйл явдлыг он цагийн дарааллаар нь цэгцтэй ойлгуулахад ашиглаж болно.

Түүхэн урт хугацааг хамарсан үйл явдлын таймлайн байна. Жишээ нь, геологийн таймлайн: http://www.talkorigins.org/origins/geo_timeline.html эсвэл нэг л үйл явдал, тухайлбал, 2001 оны 9 дүгээр сарын 11-ний үйл явдалд зориулсан таймлайн: <http://www.timerime.com/en/timeline/17434/911/> байна.

Британий номын сангийн интерактив таймлайн (зураг 1) гэхэд 1210 оноос 2000 он хүртэлх гол үйл явдлуудыг арав, арван жилээр алхамчлан харуулсан байдаг <http://www.bl.uk/learning/timeline/index.html>.

Мөн түүхч, урлагийн нэрт зүтгэлтнүүд, зохиолчдын намтар, уран бүтээлийг судлахад ашиглаж болно. Жишээ нь, Шекспирийн уран бүтээлийн таймлайныг дурдаж болно (<http://www.bardweb.net/plays/timeline.html>).

[bardweb.net/plays/timeline.html](http://www.bardweb.net/plays/timeline.html)).

Зураг 1 Шекспирийн амьдрал, уран бүтээлийн таймлайн (дэлгэцийн зураг)



Өнөөдөр өөрийн таймлайныг бүтээж, ашиглаж болох хэд хэдэн цахим үйлчилгээ бий². Үүний нэг нь TimeRime (<http://timerime.com>) юм. TimeRime үйлчилгээнд нэвтрэхийн тулд эхлээд бүртгүүлнэ (нэр, нууц үг, и-мэйл хаяг, дүрмийг хүлээн зөвшөөрсөн зэргээр). TimeRime нь дараах бүтэцтэй юм.

- Introduction (Удиртгал)
- Timelines (Таймлайн)
- Professional (Мэргэжлийн түвшинд ашиглах)

TimeRime үйлчилгээнд зөвхөн суурь бүрдлүүд нь төлбөргүй байдаг (Зураг 2). Тийм учраас бид төлбөргүй ашиглаж болох Timelines хавтсыг дэлгэрэнгүй авч үзсэн болно.

Зураг 2

TimeRime үйлчилгээн дэх таймлайны хавтас (дэлгэцийн зураг)




2 <http://www.timetoast.com>, <http://www.allofme.com> зэргийг дурдаж болно.

Таймлайн бүрт удирдлага бий. Удирдлага нь дэлгэцийн баруун дээд өнцөгт байрлана (Зураг 3). Энэ үйлчилгээний монгол хэлний хувилбар гэж байхгүй ч удирдлагын цөөн цэсийг орчуулахад хангалттай, хэрэглэхэд энгийн, хялбар гэж хэлж болно.

Зураг 3

Таймлайны удирдлага






TimeRime үйлчилгээний гол давуу тал нь бэлэн таймлайныг сургалтад ашиглахаас гадна багш, сурагчид өөрийн таймлайныг бүтээж болно. Жишээ нь “1911 оны хувьсгал”-ын түүхэн чухал

үйл явдлуудаар өөрсдийн таймлайныг бүтээцгээе. Уг хувьсгалын түүхэн чухал үйл явдлуудыг тэмдэглэе. 1911 оны 6 сарын 21-нд Халхын ноёдын нууц зөвлөгөөн болов, Орос улсаас тусламж гуйх төлөөлөгчдийг томилов, 1911 оны 7-р сарын 29-нд Орос улсаас тусламж хүсэхээр хөдлөв, 1911 оны 11-р сарын 30-нд ХХБХТЕШГ-г байгуулав, 1911 оны 12-р сарын 4-нд Саньдо амбан Монгол нутгийг орхин гарав, 1911 оны 12-р сарын 29-нд Богд хаант Монгол улс байгуулагдав.

Timeline хэсгийн *My TimeRime* хавтас руу орье. Энд “*Make a new timeline*” товчийг дарна. Таймлайны нэрийг бөглөнө (1911 оны хувьсгал), сэдвийн категорио сонгоно (бид “Түүх” категориог сонгоно), товч тодорхойлолтоо бичнэ. Манай таймлайныг бусад хэрэглэгч харж болно (Public), эсвэл зөвхөн зохиогчдод хүртээмжтэй байх (Private) эсэхийг сонгоно. Дараах зурагт “1911 оны хувьсгал” хэмээх таймлайныг бүтээх бүх үйлдлийг харуулсан болно. (Зураг 4).

Зураг 4. Таймлайныг бүтээх үйлдлүүд (дэлгэцийн зураг)






“Үйл явдлаас” гадна *TimeRime*-д үеүдийг тэмдэглэж болно. Тэдгээрийг таймлайны дор хөндлөн шугамд тусган харуулна. Жишээ нь, 1911 оны хувьсгал, 1921 оны хувьсгал зэргээр үйл явдал, үеүдийг зэрэгцүүлэн харуулж болно

Зураг 5

Үеүдийг тэмдэглэх (дэлгэцийн зураг)




Үйл явдал, үеүдийг байрлуулсны дараа түүнийг (илгээх) цахим шуудангаар илгээх, сайт, сургалтын блогтоо байршуулж болно.

Таймлайнаа хамтдаа хянан засварлаж, үйлчилгээг Web 2.0 болгох боломжтой юм. Энэ нь түүний бас нэг давуу тал юм. *Extra features* (Нэмэлт боломж) хавтас руу шилжье (Зураг

6). Ийм маягаар таймлайныг бүтээж, засварлаж (ганцаараа эсвэл хамтдаа), гадна байршуулж болно (бичиглэл байдлаар илгээх, гадны эх сурвалжид байршуулах) .

Зураг 6

Таймлайныг хянан засварлах. Дэлгэцийн зураг



Таймлайныг сургалтад ашиглах нь дээр дурдсанчлан ихээхэн үр дүнтэй юм. Түүхийн хичээлд түүнийг ашиглах зарим боломжийг дурдъя.

1. Гэрийн даалгаварт өгч болно: тухайн бүлэг сэдвээс таймлайнд 5 чухал гэж үзсэн он цагийг оруулна уу. (Үүний тулд 10 –аас доошгүй он цагийг дурдсан бүлэг сэдвийг сонгох хэрэгтэй). Ангид даалгаврыг нь шалгаж, сурагчид таймлайнаа харьцуулж, яагаад ийм сонголт хийснээ тайлбарлана.
2. Сурагч бүр хичээлийн жилийн эхэнд өөрийн таймлайныг бүтээнэ. Хичээл бүрийн дараа шинээр мэдэж авсан он цагийг оруулна. Он цаг 100 орчимд хүрвэл багш хамгийн чухал гэж үзсэн 50 он цаг эсвэл 30 он цагийг сонгох даалгавар өгнө. Хэсэг хугацааны дараа даалгавраа давтан өгнө. Ийм маягаар жилийн эцэс гэхэд тухайн хичээлээр хамгийн чухал гэсэн 100 он цагийг сурагчид тогтоож авна. Сурагчид он цагийг багшийн заавраар бус өөрсдөө чөлөөтэй сонгон авах ёстой.
3. Он цагийн хувьд зэрэгцсэн үйл явдлуудыг судлахад таймлайныг ашиглаж болно. 6 дугаар ангид Эртний түүхийг судална. Сурагчид таймлайнд дэлхийн эртний түүхийн 50 он цагийг тэмдэглэнэ. Хоёрдугаар улиралд энэ үеийн Монголын түүхийг судална. Таймлайнд энэ үеийн Монголын түүхийн 50 он цагийг оруулна. Ийм маягаар эх түүхийн тухайн үйл явдал болсон он цагт дэлхийн түүхийн ямар үйл явдал болсныг зэрэгцүүлэн үзэж болно. Ийм даалгаврыг 7-р ангид ч өгч болно.
4. Таймлайны тусламжтайгаар үйл явдлыг он цагийн дараалалд оруулах зэрэг уламжлалт

даалгаврыг сурагчдад өгч болно. Ийм даалгаварт он цагийг нарийн тодорхойлох шаардлагагүй, үйл явдлыг он цагийн дараалалд зөв оруулах нь чухал болно. Таймлайн нь үйл явдлууд хоорондоо хичнээн жилийн зайтай болсныг харуулах бөгөөд сурагчид үйл явдлууд хоорондоо хэрхэн холбогдож байгааг ойлгож авахад тусална.

5. Багш гэрийн даалгаварт он цагийг нь орхин бичсэн бичвэр өгнө. Сурагчид он цагийг нөхөн таймлайнд оруулах зэргээр түүхэн чухал үйл явдлын он цагийн мэдлэгээ шалгах жишээтэй.

ДҮГНЭЛТ

Судалгааны дүнгээс багш нарын дийлэнх нь сургалтад интернетийг ашигладаг, ихэнх сургуульд интернетийг ашиглах үндсэн нөхцөл бүрдсэн гэх үзүүлэлт гарч байгаа ч интернетийн хэрэглээ цахим лавлах, нэвтэрхий толь, сургалтын хэрэглэгдэхүүний нөөцийг ашиглах түвшинд байгаа бөгөөд интернет багшийн мэргэжлийн байнгын орон зай болж чадахгүй байгааг харуулж байна. Цахим хуудас, үйлчилгээг ашиглах, сургалтад нэвтрүүлэхэд багш нарын хувьд гадаад хэлний мэдлэг сул, вэб мэдээлэлтэй ажиллах, вэб бүтээх чадвар эзэмшээгүй зэрэг тодорхой бэрхшээл тулгарч байгаа нь харагдаж байгаа юм.

Энэхүү өгүүлэлдээ бид түүхийн сургалтад үр ашигтай ашиглаж болох нэг л цахим үйлчилгээг жишээ болгон авч үзлээ. Ийм цахим үйлчилгээ нь сургалтын чанар, үр дүнд эерэгээр нөлөөлж болох үлэмж нөөц боломжийг агуулж байна. Тийм учраас бид интернетийн нэвтэрхий толь, лавлахыг ашиглах төдийхнөөр үйл ажиллагаагаа хязгаарлах бус сургалтын цахим үйлчилгээнүүд, тэдгээрийн зориулалтыг мэдэж, сургалтад ашиглах нь чухал гэдгийг тэмдэглэн хэлье.